

## 19.4 Журнал хаах

Журнал хаах үйл ажиллагааг жилийн эцэст хийж гүйцэтгэнэ.

Цахим журнал хөтлөдөг сургуулийн багш бүр энэхүү үйл ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

**Журнал хаах үйлдлийн зорилго нь:** Багш бүр өөрийн цахим журнал хөтлөлтөнд хяналт хийх зорилготой.

Өөрөөр хэлбэл хичээл заадаг ангийн суралцагчдын дүнг бүртгэж сургалтын менежерээр баталгаажуулж дууссан. Дахин энэ үнэлгээнд өөрчлөлт оруулахгүй журнал хөтлөлт гүйцэт болсон гэж үзэж байгааг баталгаажуулсан үйл ажиллагаа юм.

**Хийгдэх үйлдэл:** Сургуулийн бүх багш нар (**1, 2-р ангийн багш нар үнэлгээ 2 бүртгэхгүй**) хичээл заадаг ангийнхаа **үнэлгээ 2**-ын дүнг 1 болон 2-р хагас жилийн дүнг бүртгэж сургалтийн менежерээр баталгаажилт хийлгэсний дараа журнал хаах үйлдэл хийнэ.